ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Мөнхийн алба эрүүл мэндийн төв-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/113/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. **Аудитын санал дүгнэлт** ..................... 2

2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..................... 4

   2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ..................... 5

   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..................... 7

   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..................... 8

   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..................... 10

3. **Аудитын тайлан**

   3.1 Ерөнхий зүйл ..................... 12

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..................... 12

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..................... 12

   3.4 Материаллаг байдал ..................... 13

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..................... 13

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..................... 14

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..................... 14

   3.8 Аудитын гол асуудал ..................... 14

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ..................... 14

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..................... 15

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................... 15

4. **Аудитын илрүүлэлт** ..................... 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1902/242
танай ______ -ны № ______ -т

МӨНХИЙН АЛБА ӨЭМТ-ИЙН
ЭРХЛЭГЧ Л.ТУНГАЛАГ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнхийн алба өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнхийн алба өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

0120253

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,422,029.97** | **43,988,358.86** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 13,647,863.23 | 278,808.86 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 13,647,863.23 | 278,808.86 |
| **3121** | **Төгрөг** | 13,647,863.23 | 278,808.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 13,647,863.23 | 278,808.86 |
| **33** | **АВЛАГА** | 2,377,519.10 | 12,171,200.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 12,171,200.00 |
| **335** | **Бусад авлага** | 2,377,519.10 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,377,519.10 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 22,396,647.64 | 31,538,350.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 9,887,177.64 | 18,306,974.00 |
| 35130 | Эм боох материал | 9,887,177.64 | 18,306,974.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,509,470.00 | 13,231,376.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 119,500.00 | 30,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,899,230.00 | 4,456,680.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 45,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,860,000.00 | 1,610,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 50,000.00 | 50,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,580,740.00 | 7,039,596.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **73,654,401.79** | **66,385,310.82** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 73,654,401.79 | 66,385,310.82 |
| **392** | **Биет хөрөнгө** | 66,407,151.79 | 59,269,310.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 42,003,990.00 | 42,003,990.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (7,252,878.24) | (10,879,317.36) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,595,440.00 | 21,595,440.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,645,440.00) | (13,635,439.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 29,392,628.00 | 34,131,278.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (11,837,711.74) | (16,791,711.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,245,328.00 | 18,245,328.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,094,204.23) | (15,400,256.76) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 300,000.00 | 300,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (300,000.00) | (300,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,247,250.00 | 7,116,000.00 |
| 39301 | Програм хангамж | 630,000.00 | 630,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (498,750.00) | (630,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,116,000.00 | 7,116,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **112,076,431.76** | **110,373,669.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,154,290.31** | **10,436,113.65** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,154,290.31 | 10,436,113.65 |
| **413** | **Өглөг** | 1,154,290.31 | 10,436,113.65 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 869,290.31 | 2,073,013.65 |
| **4136** | **Бусад өглөг** | 285,000.00 | 8,363,100.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 8,363,100.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 285,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **110,922,141.45** | **99,937,556.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 110,922,141.45 | 99,937,556.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 35,108,550.00 | 35,108,550.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 35,108,550.00 | 35,108,550.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 57,770,703.17 | 46,786,117.76 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 57,770,703.17 | 57,770,703.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (10,984,585.42) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 18,042,888.28 | 18,042,888.28 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **112,076,431.76** | **110,373,669.68** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **247,441,967.64** | **295,205,847.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,567,667.64** | **17,789,404.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,567,667.64 | 17,789,404.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,490,423.64 | 17,789,404.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,490,423.64 | 17,789,404.00 |
| 120009 | Бусад орлого | 77,244.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **238,874,300.00** | **277,416,443.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 204,213,100.00 | 220,988,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 204,213,100.00 | 220,988,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,180,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд | 4,180,000.00 | - |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 509,000.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 509,000.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 29,972,200.00 | 56,427,843.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 91,543.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,972,200.00 | 56,336,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **198,531,200.87** | **306,190,432.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **198,531,200.87** | **306,190,432.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 198,161,200.87 | 283,790,432.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,753,504.00 | 194,779,894.00 |
| 210101 | Үндсэн цалин | 157,753,504.00 | 194,779,894.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,168,248.54 | 22,538,390.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,233,806.54 | 17,583,116.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 389,686.00 | 1,048,135.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 311,749.00 | 677,010.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 77,937.00 | 169,252.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,155,070.00 | 3,060,875.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,775,969.44 | 4,411,170.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 295,969.44 | 371,170.20 |
| 210302 | Түлш, халаалт | 2,480,000.00 | 4,040,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,272,320.00 | 4,859,815.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,371,550.00 | 985,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,551,360.00 | 2,665,415.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 595,770.00 | 601,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 753,640.00 | 608,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,324,146.00 | 40,751,421.64 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,414,646.00 | 40,751,421.64 |
| 210502 | Хоол, хүнс | 909,500.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,760.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 61,760.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,124,500.00 | 1,098,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,124,500.00 | 1,098,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,617,042.00 | 2,470,200.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,523,650.00 | 1,697,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 648,736.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 50,064.50 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 93,392.00 | 74,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,063,710.89 | 12,881,540.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 630,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 243,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,063,710.89 | 12,007,740.97 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 370,000.00 | 22,400,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 370,000.00 | 22,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 370,000.00 | 22,400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **48,910,766.77** | **(10,984,585.42)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **48,910,766.77** | **(10,984,585.42)** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 27,992,550.00 | 7,619,331.00 | 8,855,908.96 | 44,467,789.96 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **27,992,550.00** | **7,619,331.00** | **8,855,908.96** | 44,467,789.96 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 7,116,000.00 | - | (2,410,151.48) | 4,705,848.52 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **57,770,703.17** | 110,922,141.45 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **57,770,703.17** | 110,922,141.45 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **57,770,703.17** | 110,922,141.45 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (10,984,585.42) | (10,984,585.42) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **46,786,117.76** | 99,937,556.03 |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **238,951,544.00** | **265,701,654.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,244.00** | **456,411.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 77,244.00 | 456,411.00 |
| 120009 | Бусад орлого | 77,244.00 | 456,411.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **238,874,300.00** | **265,245,243.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 204,213,100.00 | 220,988,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 204,213,100.00 | 220,988,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,180,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,180,000.00 | - |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 509,000.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 509,000.00 | - |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 29,972,200.00 | 44,256,643.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 91,543.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,972,200.00 | 44,165,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **203,715,862.77** | **279,070,708.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **203,715,862.77** | **279,070,708.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **203,345,862.77** | **256,670,708.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 159,570,259.10 | 191,366,536.26 |
| 210101 | Үндсэн цалин | 159,570,259.10 | 191,366,536.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,879,722.23 | 22,826,916.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,945,280.23 | 17,871,642.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 389,686.00 | 1,048,135.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 311,749.00 | 677,010.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 77,937.00 | 169,252.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,155,070.00 | 3,060,875.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,015,969.44 | 4,161,170.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 295,969.44 | 371,170.20 |
| 210302 | Түлш, халаалт | 3,720,000.00 | 3,790,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,794,150.00 | 5,317,865.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,329,750.00 | 885,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,551,360.00 | 2,665,415.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 595,770.00 | 601,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,363,950.00 | 1,076,850.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,953,320.00 | 89,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,282,460.00 | 28,226,220.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,838,960.00 | 28,226,220.00 |
| 210502 | Хоол, хүнс | 889,500.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,554,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,760.00 | 330,000.00 |
| 210602 | Тавилга | - | 285,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 61,760.00 | 45,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,124,500.00 | 1,098,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,124,500.00 | 1,098,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,617,042.00 | 2,470,200.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,523,650.00 | 1,697,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 648,736.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 50,064.50 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 93,392.00 | 74,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 873,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 873,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **370,000.00** | **22,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 370,000.00 | 22,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 370,000.00 | 22,400,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **35,235,681.23** | **(13,369,054.37)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **21,613,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,613,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 21,613,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,613,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(21,613,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 13,622,681.23 | (13,369,054.37) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 25,182.00 | 13,647,863.23 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13,647,863.23 | 278,808.86 |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 207,539,200.00 | 279,070,708.37 | (71,531,508.37) | 134% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 207,539,200.00 | 279,070,708.37 | (71,531,508.37) | 134% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 207,139,200.00 | 256,670,708.37 | (49,531,508.37) | 124% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166,492,400.00 | 191,366,536.26 | (24,874,136.26) | 115% |
| 210101 | Үндсэн цалин | 166,492,400.00 | 191,366,536.26 | (24,874,136.26) | 115% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,146,800.00 | 22,826,916.41 | (3,680,116.41) | 119% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,146,800.00 | 17,871,642.69 | 1,275,157.31 | 93% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 1,048,135.11 | (1,048,135.11) | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 677,010.10 | (677,010.10) | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 169,252.77 | (169,252.77) | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 3,060,875.74 | (3,060,875.74) | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,550,000.00 | 4,161,170.20 | (611,170.20) | 117% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 350,000.00 | 371,170.20 | (21,170.20) | 106% |
| 210302 | Түлш, халаалт | 3,200,000.00 | 3,790,000.00 | (590,000.00) | 118% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,950,000.00 | 5,317,865.00 | (367,865.00) | 107% |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 885,600.00 | 314,400.00 | 74% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,600,000.00 | 2,665,415.00 | (1,065,415.00) | 167% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 601,000.00 | (1,000.00) | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,550,000.00 | 1,076,850.00 | 473,150.00 | 69% |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 89,000.00 | (89,000.00) | |
| **2105** | **Нормативт зардал** | 9,000,000.00 | 28,226,220.00 | (19,226,220.00) | 314% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,000,000.00 | 28,226,220.00 | (19,226,220.00) | 314% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 330,000.00 | 170,000.00 | 66% |
| 210602 | Тавилга | - | 285,000.00 | (285,000.00) | |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 45,000.00 | 455,000.00 | 9% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,500,000.00 | 1,098,000.00 | 2,402,000.00 | 31% |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,500,000.00 | 1,098,000.00 | 2,402,000.00 | 31% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 2,470,200.50 | (2,470,200.50) | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,697,000.00 | (1,697,000.00) | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 648,736.00 | (648,736.00) | |
| 210807 | Газрын төлбөр | - | 50,064.50 | (50,064.50) | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 74,400.00 | (74,400.00) | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 873,800.00 | (873,800.00) | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 873,800.00 | (873,800.00) | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 400,000.00 | 22,400,000.00 | (22,000,000.00) | 5600% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 22,400,000.00 | (22,000,000.00) | 5600% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 22,400,000.00 | (22,000,000.00) | 5600% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 29,678,400.00 | 265,245,243.00 | (235,566,843.00) | 894% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 220,988,600.00 | (220,988,600.00) | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 220,988,600.00 | (220,988,600.00) | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | - | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,678,400.00 | 44,256,643.00 | (14,578,243.00) | 149% |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 91,543.00 | (91,543.00) | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 29,678,400.00 | 44,165,100.00 | (14,486,700.00) | 149% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 13,647,863.23 | (13,647,863.23) | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 278,808.86 | (278,808.86) | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мөнхийн албан эрүүл мэндийн төв-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч  байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Мөнхийн алба эрүүл мэндийн төв-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнхийн алба эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөнхийн алба эрүүл мэндийн төв  нь Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн заслын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, Эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ оношилгоо, шинжилгээ хийх, Сумын хүн амын нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоог хангаж, орчны эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулахад зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөнхийн алба эрүүл мэндийн төв нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнхийн алба өрхийн эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 241,441.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,400.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 1,680.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 13,647.8 | 278.8 | -13,369.0 |
| Авлага | 2,377.5 | 12,171.2 | 9,793.7 |
| Бараа | 22,396.6 | 31,538.3 | 9,141.7 |
| Үндсэн хөрөнгө | 73,654.4 | 66,385.3 | -7,269.1 |
| **Нийт хөрөнгө** | **112,076.3** | **110,373.6** | **-1,702.7** |
| Өр төлбөр | 1,154.2 | 10,436.1 | 9,281.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 110,922.1 | 99,937.5 | -10,984.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **112,076.3** | **110,373.6** | **-1,702.7** |

Авлага дансны үлдэгдэл 9,793.7 мянган төгрөгөөр өссөн нь ковидын татаас санхүүжилтийн болон хувь хүмүүстэй хийх тооцооны авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын данс нь үлдэгдэл 9,141.7 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал, эм боох материалын нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны 7,269.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлтэй хамааралтай байна. Тайлант хугацаанд хандиваар 4,738.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж олж бэлтгэсэн байна.

Өглөг дансы үлдэгдэл 9,281.9 мянган төгрөгөөр өссөн нь Татварын байгуулагад төлөх ХХОАТ-ын 2,073.01 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 7,208.9 мянган төгрөгөөр тус тус өссөн . Тухайн өглөг нь ковидын зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,984.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 207.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төвлөрсөн төсөвөөс 220,988.6 мянган төгрөгийн санхүүжилт, НД-н сангийн төсвөөс 44,256.6 мянган төгрөгийн, бусад орлогоос 456.4 мянган төгрөгийн, нийт 265,701.6 мянган төгрөгийн санхүүжилтыг бүрдүүлсэн байна. Тайлант хугацаанд 279,070.7 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлан онд Мөнхийн алба эрүүл мэндийн төв нь нэмэлт санхүүжилтийн орлого бүрдүүлээгүй байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаа хоцроосон мэдээлэл 1, огт мэдээллээгүй 3 мэдээлэл байна.

Хугацаа хоцроосон болон огт мэдээллээгүй мэдээлэл нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээлэлийг 1-р улиралд хоцроож, 2,3,4 улиралд мэдээллээгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа эсэхийг шалгах үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,216.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,216.5 мянган төгрөгийн алдааг завсарын аудитааар залруулж 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- ✓ Гэрэл цахилгааны зардал 234.1 мянган төгрөгийг шууд зардалд бичсэн тооцооны дансаар дамжуулаагүй зөрчил илэрсэн тооцоо үүсгэн бичилт хийсэн байна.
- ✓ 01 сарын 28-ны өдрийн гүйлгээгээр Л.Тунгалагт 80.0 мянган төгрөгийг өглөгт тусгалгүй дараа онд томилолтын зардалаар олгосон.
- ✓ 01 сарын 28-ны гүйлгээгээр Ж.Самбуу, Б.Энхтүвшин, Д.Цогт-Очир нарт 450.0 мянган төгрөгийг тооцоо үүсгэлгүй шууд зардалд тусгасан залруулга хийж тооцоо үүсгэсэн байна.
- ✓ 02 сарын 01-ны гүйлгээгээр МӨАУМХолбооноос авсан гарын авлага ном сэтгүүлийн үнэ 120.0 мянган төгрөгийг шууд зардалд тусгасаныг орлогот авч тооцоо үүсгэлээ.
- ✓ 3-р улирлын тооцоогоор НДШ-ийн өглөг тайланд тусгагдаагүй боловч НД-ын онлайн тайлангаар 4,172.4 мянган төгрөгийн өглөгтэй жилийн эцсээр тооцооны үлдэгдэлгүй.
- ✓ Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй
- ✓ 01-09 сарын жолоочийн тооцооны хуудасыг хөтөлж тооцоог хийж жилийн эцсээр ирүүлсэн байна.

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

### 4.4 Зөвлөмж

1.1. **<u>Өгсөн зөвлөмж</u>:** Өөрийн байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох, мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мөнхийн алба ӨЭМТ | 7 | 7.2 | 6 | 7.2 | - | - | - | - | 1 | - |